



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГА О.ГАНБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013. 03. 25 № 06/25 ЧАДВАЛГАЗРЫН СТАМП

Зөрчил арилгах тухай

Гаалийн ерөнхий газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар гаалийн татварын тайланд авлагаар бүртгэгдсэн Моннис Интернэшнл ХХК-ийн гаалийн татварын 1956.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй зөрчил илэрсэн нь Гаалийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4, Засгийн газрын 2009 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Гаалийн болон бусад татвар төлөх, баталгаа гаргах журам”-ын 6.1-д “Банкны баталгаа болон бараа барьцаалах гэрээний хугацаа нь гаалийн бичиг баримтын бүрдүүлэлт хийсэн өдрөөс хойш 2 сар хүртэл хугацаанд хүчинтэй байна” гэж заасныг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дээрх гаалийн татварын 1956.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх, дээрх алдаа, зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дарга О.Ганбат, Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, ерөнхий няглан бодогч А.Болор-эрдэнэ нарт үүрэг болгож, албан шаардлага хүргүүлж байна.

Албан шаардлагын биелэлтийг 2013 оны 06 дугаар сарын 25 -ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Ч.БОЛД

073218